



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 5/20

Ховд

Б.Алтангэрэлийг түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 168 дугаар тогтоолоор аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын бүтцэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор аймгийн Боловсролын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Бямбасүрэнгийн Алтангэрэлийг 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Алтангэрэлд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-10-3 дахь шатлал буюу 981742 төгрөг /есөн зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин хоёр/-өөр цалинжуулахыг нягтлан бодогч /Б.Уугантуяа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ